



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2019 оны 10 сарын 10 өдөр

Дугаар 387

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө нээлттэй дуудлагын
худалдаагаар худалдах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны "Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай" 268 дугаар тогтоолын 3, 4.2, 4.3 дахь заалт, "Мэдээ тайлангийн маягт батлах тухай" 269 дүгээр тогтоолын 2.3 дахь заалтыг тус тус үндэслэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн 20 дугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Байгаль орчин, аялал жуулчлалын яамны харьяа байгууллагуудын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй сэргээн засварлах боломжгүй болсон нийт 208,076,225.00 (хоёр зуун найман сая далан зургаан мянга хоёр зуун хорин таван) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан 15 ширхэг автомашиныг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу тогтоосугай.

2. Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн дарга Ц.Цэнгэл, харьяа байгууллагуудын дарга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Үндсэн хөрөнгийг дуудлагын худалдаагаар худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Дуудлагын худалдааг зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулах, дуудлагын худалдаанаас олох орлогыг (дуудлагын худалдааны зардлыг хассан дүнгээр) зохих журмын дагуу улсын төсөвт төвлөрүүлэх;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.4. Энэ тогтоолын биелэлтийг холбогдох мэдээ тайлангийн маягт, хөрөнгийн үнийг төвлөрүүлсэн баримтын хамт 2019 оны 4 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.


ДАРГА

3.МЭНДСАЙХАН

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

А.АРИУНБОЛД

Байгаль орчин, аялал жуулчлалын яамны харьяа байгууллагуудын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах тээврийн хэрэгсэл



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн 381 дугаар тогтоолын хавсралт

д/д	Автомашинны марк, улсын дугаар, зориулалт, хөдөлгүүр, арлын дугаар	Үйлдвэрлэсэн, ашиглалтад орсон он	Нийт гүйлт /км/	Балансын үнэ /төгрөг/	Хуримтлагдсан элэгдэл /төгрөг/	Үлдэх өртөг /төгрөг/	Сэргээн босголтын зардал /төгрөг/	Худалдах доод үнэ /төгрөг/
1. Улаан тайгын улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргаа								
1	УАЗ-469 суудлын, 40-37 УБТ, арал 70587654, хөдөлгүүр 70701951	2008/2008	123260	11,906,800.00	11,906,800.00	-	-	800,000.00
	Дүн			11,906,800.00	11,906,800.00			800,000.00
2. Говь-Гурвансайханы байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа								
1	УАЗ-331519 суудлын, 54-35 УБК, арал 30563792, хөдөлгүүр 10347480	2003/2003	116173	10,347,480.00	10,347,480.00	-	-	800,000.00
2	УАЗ-22069-033 фургон суудлын, 78-58 ӨМӨ, арал 80467661, хөдөлгүүр 80501263	2008/2008	105297	15,800,000.00	15,800,000.00	-	-	1,000,000.00
	Дүн			26,147,480.00	26,147,480.00		-	1,800,000.00
3. Түжийн нарсны байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа								
1	УАЗ-31512 фургон суудлын, 49-65 СБА, арал 80510029	2006/2008	298713	14,280,000.00	14,280,000.00	-	1,000,000.00	1,000,000.00
	Дүн			14,280,000.00	14,280,000.00		1,000,000.00	1,000,000.00
4. Хөвсгөлийн улсын тусгай хамгаалттай газрын хамгаалалтын газрын захиргаа								
1	УАЗ-31512 суудлын, 83-53 ХӨА, арал 70569685, хөдөлгүүр 60018727	2007/2007	68332	13,190,000.00	13,190,000.00	-	-	800,000.00

	Дүн			13,190,000.00	13,190,000.00			800,000.00
5.Богдхан уулын Дархан цаазат газрын хамгаалалтын захиргаа								
1	УАЗ-31519 суудлын, 67-38 УНП, арал 134198, хөдөлгүүр 70901337	2007/2007	140000	15,800,000.00	15,800,000.00		-	800,000.00
2	УАЗ-31519 суудлын, 67-42 УБЭ, арал 80594886, хөдөлгүүр 71000077	2007/2007	180000	15,800,000.00	15,800,000.00		-	800,000.00
	Дүн			31,600,000.00	31,600,000.00			1,600,000.00
6.Онон-балжийн байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа								
1	УАЗ-22069033 фургон, 2280 ХЭУ, арал 374100С0002171, хөдөлгүүр 410400С0002171	2012/2012	280000	20,800,000.00	20,800,000.00	-	900,000.00	1,000,000.00
	Дүн			20,800,000.00	20,800,000.00		900,000.00	1,000,000.00
7.Отонтэнгэрийн улсын тусгай хамгаалттай газрын хамгаалалтын газрын захиргаа								
1	УАЗ-31512 суудлын, 6427 УБВ, арал 70581627, хөдөлгүүр 7005016	2007/2007	445000	12,822,263.00	12,822,263.00		-	800,000.00
	Дүн			12,822,263.01	12,822,263.00			800,000.00
8.Хар ус нуурын улсын тусгай хамгаалттай газрын хамгаалалтын газрын захиргаа								
1	УАЗ-31512 суудлын, 2933 ХОА, арал 70583296, хөдөлгүүр 7005652,	2007/2007	180000	16,483,500.00	16,483,500.00	-	-	800,000.00
2	УАЗ-390942 ачааны, арал 330360А0424011, 1232 ХОУ, хөдөлгүүр А0002263,	2010/2011	210000	16,800,000.00	16,800,000.00	-	-	800,000.00
	Дүн			33,283,500.00	33,283,500.00			1,600,000.00
9.Говийн бага дархан цаазат газрын хамгаалалтын захиргаа								
1	УАЗ-220692 Фургон суудлын 49-08 ОМА,арал 30470636	2003/2008	595188	10,480,000.0	10,480,000.00	-	-	800,000.00

2	ISUZU VIGNORN суудлын 54-75 УБЦ арал UBS69GW7279704	1997/2010	206966	8,000,000.0	8,000,000.00	-	-	800,000.00
	Дүн			18,480,000.00	18,480,000.00			1,600,000.00
10. Хан хэнтий улсын тусгай хамгаалттай газрын хамгаалалтын газрын захиргаа								
1	УАЗ31519 65-05 УБК арал 30563782.	2003/2003	245000	9,326,882.00	9,326,882.00	-	-	800,000.00
	Дүн			9,326,882.00	9,326,882.00			800,000.00
11. Сүхбаатар аймгийн Ус, цаг уур орчны шинжилгээний төв								
1	УАЗ-31512 суудлын, 12-12 СУА, арал 70586585, хөдөлгүүр 70006554	2007/2007	178000	16,239,300.00	16,239,300.00	-	-	800,000.00
	Дүн			16,239,300.00	16,239,300.00			800,000.00
	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН			208,076,225.00 (хоёр зуун найман сая далан зургаан мянга хоёр зуун хорин таван)			1,900,000.00 /нэг сая есөн зуун мянган/	12,600,000.00 (арван хоёр сая зургаан зуун)